

**АШИГТ МАЛТМАЛЫН 1997 БОЛОН 2006 ОНЫ ХУУЛИУДЫН
ХУРААНГУЙ ХАРЬЦУУЛАЛТ**

1. Өмнөх хуулийн ашигт малтмал нь төрийн өмч бөгөөд хайх, ашиглах эрхийг бусдад олгох эрхтэй гэсэн заалтууд дээр улсын төсвийн оролцоотой хайгуул хийсэн эсэхээс болон стратегийн ач холбогдолтой орд эсэхээс нь хамаарсан төрийн эзэмшиж болох хувийг тогтоож өгсөн.
2. Хуулийн шинэчилсэн найруулгад ашигт малтмалын ордын ангилалыг шинээр нэмсэн /3 төрөл/.
3. УИХ, ЗГ, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг ерөнхий нэг зүйлд байсныг дэлгэрүүлэн тус тусад нь нэг зүйлээр зохицуулсан.
4. Талбайн нөөцөд авах хугацаа 3 жил байсныг хассан ба нөөцөд авах 2 үндэслэл дээр “улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийх, ашигт малтмал эрэх, хайх” гэснийг шинээр нэмсэн.
5. Тусгай хэрэгцээний газрын зохицуулалт дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:
 - a. Тодорхой газрыг тусгай хэрэгцээнд байлгах хугацаа 5 жилээс доошгүй байх тухай нэмсэн.
 - b. Нөхөн олговрыг олгох хугацааг тодорхой болгосон /1 жилийн дотор/.
 - c. Нэмсэн: “Нөхөх олговрыг тогтоосон хугацаанд нь төлөөгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах эрхтэй.”
 - d. Нэмсэн: Тусгай хэрэгцээнд байх хугацаа дууссантай холбоотой заалтууд
6. Тойм судалгаа:

Өмнө нь тусгай хэрэгцээний газарт тусгай зөвшөөрөлгүй судалгаа явуулж болох байсныг зөвхөн зөвшөөрөлтэй явуулах болгосон.
7. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа болон эрдэм шинжилгээний ажлын талаарх шинэ заалт нэмсэн. /2006 оны хуулийн 16 дугаар зүйл/
8. 1997 оны хууль дээр “лиценз эзэмших эрх бүхий этгээд” гэсэн 10-р зүйлийг 2006 оны 7 дугаар зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмалэрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага” болгон хэд хэдэн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулсан.
9. Хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн захиргааны байгууллага, Үндэсний геологийн албаны чиг үүргийг дэлгэрүүлсэн.
10. 1997 оны хуулийн 11-р зүйл дэх “Лицензгүйгээр ашигт малтмалыг хайх, ашиглахыг хориглох” тухай заалтыг хассан.
11. 2006 оны хуулиар дараах зохицуулалтуудыг дэлгэрүүлсэн эсвэл өөрчлөн найруулсан. Үүнд:
 - a. Хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигчийн эрх, үүрэг, тавигдах шаардлага
 - b. Хайгуулын болон ашиглалалтын лиценз авах өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх журам
 - c. Хайгуулын болон ашиглалтын лицензийн хугацааг сунгах
 - d. Лицензийн төлбөртэй холбоотой асуудал
 - e. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг
 - f. Уурхай хаагдах үед тавигдах шаардлага

12. 2006 оны хуульд шинээр “Чөлөөлөгдсөн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох” 20 дугаар зүйлийг нэмсэн.
13. 1997 оны хуульд байсан тогтвортой байдлын гэрээтэй холбоотой заалтуудыг хассан.
14. Байгаль орчинтой холбоотой багагүй заалтыг шинэ хуулинд хэвээр үлдээсэн байх ба хэд хэдэн заалтыг шинээр нэмж, зарим заалтыг бага зэрэг өөрчилсөн байна.
15. Соёлын өвийг хамгаалах талаар шинээр нэмсэн.
16. Өмнөх хуулинд тэргүүн ээлжинд Монгол улсын иргэнийг авч ажиллуулна гэсэн заалтыг өөрчилж, гадаадын иргэн нийт ажиллагсдын 10 хувь байж болохоор заан түүнээс дээш тохиолдолд төлбөр төлөхөөр болгожээ.
17. Үнэт металл, эрдэнийн чулуутай холбогдолтой заалтуудын хувьд 2006 оны хуульд “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 400 граммаас дээш жинтэй, эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монголбанкны төрийн эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй” гэсэн 46-р зүйлийн 46.5 дах заалтыг нэмсэн.
18. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой өөрчлөлтүүд:
 - a. Улс болон орон нутгийн төсөвт төлөхөөр байсныг зөвхөн улсын төсөв болгосон.
 - b. Борлуултын үнэлгээг тооцох журам
 - c. Төлбөрийн хэмжээ
 - d. Хайгуулын лиценз эзэмшигч борлуулан ашиглагчтай адил хэмжээгээр төлбөр төлж болохоор заасан
 - e. Нэмсэн: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна./2006 оны хуулийн 47.13/
19. Мэдээ тайлан:
 - a. “Өмнөх хуулиар мэргэжлийн хяналтын байгууллага болон Геологи, уул уурхайн кадастрын алба”-нд гаргах байсныг “төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын алба”-н гаргах болгосон.
 - b. Хайгуулын болон ашиглалтын лицензтэй хуулийн этгээдийн ямар тайланг хэдийг гаргах огноог тодорхой тусгасан.
20. Лиценз шилжүүлэх талаар 2006 оны хуульд орсон өөрчлөлтүүд:
 - a. Хайгуулын болон ашиглалтын лицензтэй этгээдүүдийн хувьд шилжүүлэхийн тулд нотлогдсон байх зүйлийг тусад нь тусгасан. /49.2, 49.3/
 - b. Шилжүүлэх өргөдөлд хавсаргах материалыг нэмэгдүүлсэн.
 - c. Төрийн захиргааны байгууллага өргөдөл хүлээн авсны дараа тодруулах зүйл гэсэн заалтыг нэмсэн. / 49.5 /
 - d. Өргөдлийн хариу өгөх хугацаа 15 өдөр байсныг 5 өдөр болгосон. /49.6/
 - e. Бусад
21. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон тайлбайн тодорхой хэсгийг шилжүүлэх зохицуулалтыг бага зэрэг өөрчилсөн.
22. Өмнөх хуульд байсан “Лиценз барьцаалагдсан байх үед уг лицензийг барьцаалагч албан бичгээр зөвшөөрсөн эсхүл хайгуулын лицензийг өв залгамжлагчид шилжүүлэхээс бусад тохиолдолд тухайн лицензийг бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг хассан ба барьцаалах талаар шинэ хуульд дараах заалтуудыг нэмсэн:
 - a. Лиценз нь дангаараа барьцааны зүйл болохгүй тухай.

- b. 51.6-д “Тухайн тусгай зөвшөөрөл барьцаалагч нь уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүрэг хүлээхгүй”.
 - c. Лиценз эзэмшигч барьцааны гэрээгээ биелүүлэхээргүй болсон болон хугацаа дуусгавар болох буюу хүчингүй болохтой холбоотой заалтууд
23. Лиценз дуусгавар болох:
Холбогдолтой зохицуулалтууд хоёр хуульд ойролцоо байх бөгөөд 2006 оны хуульд “Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаар энэ хуулийн 38, 39, 45 дугаар зүйл болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй” гэсэн 53.3-р зүйлийг нэмсэн.
24. Лиценз олгогдсон талбайг бүхэлд нь буцааж өгөх:
Өмнөх хуулийн 46.6-д байсан “Хэрэв талбайгаа буцааж өгөгч нь аж ахуйн нэгж, байгууллага бол тухайн лиценз эзэмшигч этгээдийн санал өгөх эрхийнх нь 50 хувиас илүүг эзэмшдэг, эсхүл тухайн лиценз эзэмшигч санал өгөх эрхийнх нь 50-иас дээш хувиас дээш хувийг эзэмшдэг гуравдагч этгээдэд энэ заалт нэгэн адил хамаарна” гэсэн заалтыг хассан.
25. Лиценз олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгөх: Шинэчилсэн найруулгад дараах заалтуудыг нэмсэн:
- a. 55.6.Төрийн захиргааны байгууллага тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан авсан тухай зохих байгууллагадмэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
 - b. 55.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч талбайн тодорхой хэсгийг буцаан өгснөөс хойш 2 жилийн хугацаанд тухайн талбайд дахин өргөдөл гаргах эрхгүй.
26. Лиценз цуцлах зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулсан.
27. Шинэчилсэн найруулгад дараах асуудлыг шинээр оруулсан. Үүнд:
- a. Ашигт малтмалтай холбоотой мэдээлэл, бүртгэлтэй танилцах;
 - b. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр;
 - c. Уул уурхайн үйлдвэрлэлийн санхүү, бүртгэлийн онцлог.
28. Хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг өөрчилсөн.